

Ангилалтын код

Автомашины их бие засвар - ангилал ерөнхий шаардлага	Төсөл

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний зөвлөлийноны...сарын...өдрийн ...дугаар тогтоолоор батлав

1. Зорилго

Энэхүү стандартын зорилго нь автомашины их биеийг засварлах /цаашид Автомашины их биеийн засвар/ гэх үйлчилгээ эрхлэх байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд тавигдах нийтлэг шаардлагыг тодорхойлох ба уг ажил үйлчилгээг зохион байгуулах хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2. Хамрах ба хэрэглээ хүрээ

Энэхүү стандарт нь автомашины их бие засварын үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж байгууллага, иргэн болон түүнд хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтан мөрдөж, автомашины их биеийн засварын ажил үйлчилгээнд тавих шаардлагыг тогтооход хамаарна.

3. Норматив ишлэл

Энэхүү стандартыг боловсруулахад ашигласан дараах баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалаас иш татаж хэрэглэнэ.

-MNS 5025 :2010 Авто үйлчилгээ-Ангилал, Ерөнхий шаардлага.

-MNS 4601:2011 Авто тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ засварын тогтолцоо, тодорхойлолт .

-MNS 4598:2011 Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавигдах шаардлага

-MNS 5342:2007 Авто зогсоол, Ангилал ба ерөнхий шаардлага

-MNS5347:2003 Автомашины угаалгын үйлчилгээ, Ангилал ерөнхий шаардлага

-БНДБ31-03-03, Олон нийт, иргэний барилгын норматив, дүрэм.

-БНДБ31-04-06, Хот суурины гудамж талбайн төлөвлөлтийн норматив, дүрэм

4. Нэр томъёо, тодорхойлолт

4.1 Автомашины их биеийн засвар - гэж Автомашины их биеийг зориулалтын ажлын байр, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, зориулалт бүхий стандартын шаардлага хангасан материал ашиглан солих, будах, нимгэн төмөр засварлах үйл ажиллагааг

4.2 Автомашины их бие засвар эрхлэгч - Автомашины их бие засварын үйлчилгээ эрхлэгчдэд тавигдах нөхцөл шаардлагад нь ХАБЭА-н (хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй) болон ОБЕГ-н (онцгой байдлын ерөнхий газрын) бүрэн шаардлагад нийцсэн зориулалтын барилга байгууламж, ажлын байр, зориулалт бүхий тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон мэргэжлийн үнэмлэх диплом, гэрчилгээтэй мэргэжлийн боловсон хүчин зэргээр хангагдсан байгууллага аж ахуйн нэгж иргэнийг

- 4.3 Автомашины их биеийн засварын технологи – Автомашины их биеийн гэмтэлтэй хэсгийг засварлах , солих, будах, ажилбаруудыг ХАБЭА-н (хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй) болон ОБЕГ-н (онцгой байдлын ерөнхий газрын) бүрэн шаардлага хангасан барилга байгууламжинд зориулалтын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар тодорхой цаг хугацаанд зохих нөхцөл шаардлагын дагуу технологийн дагуу чанарын шаардлага хангасан материалаар мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэх ажлын дарааллыг
- 4.4 Технологийн карт – Автомашины их биеийн засварын ажилбаруудын дэс дараалал, ажиллах боловсон хүчин , засварын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, зориулалт бүхий материал, ажил гүйцэтгэх хугацаа зэргийг тусгасан техникийн баримт бичиг байна
- 4.5 Автомашины их биеийн засварчин – ХАБЭА-н (хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй) сургалт, хичээлийн хөтөлбөрт хамрагдсан болон Автомашины их биеийг засварлах техник технологи ажиллагааг шаардлагын дагуу хийж гүйцэтгэх мэргэжлийн боловсон хүчин
- 4.5.1 Нимгэн төмөрчин
 - 4.5.2 Өнгөлгөөчин
 - 4.5.3 Будагчин
 - 4.5.4 Замаскачин
- 4.6 Автомашины засварын байр – ХАБЭА-н (хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй) болон ОБЕГ-н (онцгой байдлын ерөнхий газрын) бүрэн шаардлагад нийцсэн зориулалтын барилга байгууламж, ажлын байр, зориулалт бүхий тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл бүхий ажиллах орчинг

5. Ангилал

- 5.1 Автомашины их биеийг засварлахад ашиглаж байгаа материал, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийн ажиллагаа, ажлын байр хүний нөөцөөс хамааруулан иж бүрэн үйлчилгээтэй, хэсэгчилсэн үйлчилгээтэй гэж ангилна.
- 5.1.1 Иж бүрэн үйлчилгээтэй – Зориулалтын нөхцөл шаардлага хангасан авто их биеийн нимгэн төмөрчин, өнгөлгөөчин, будагчин, замаскачин нь засварын байрны технологи тоног төхөөрөмж багажийг бүрэн эзэмшсэн, зориулалтын угаалгын байр талбай, будгын камер бүхий үйлчилгээний газрыг
 - 5.1.2 Хэсэгчилсэн үйлчилгээтэй - Зориулалтын нөхцөл шаардлага хангасан авто их биеийн нимгэн төмөрчин, өнгөлгөөчин, будагчин, замаскачин нь аль нэг төрлөөр дагнасан үйлчилгээ үзүүлдэг, өөрийн гэсэн зориулалтын угаалгын талбайтай бус, будгийн камер бүхий газрыг

6. Автомашины их бие засварын технологи

- 6.1 Засвар үйлчилгээ хийх автомашиныг зориулалтын автомашины их бие засварын газрын барилга байгууламжийн шаардлага хангасан газар байрлуулж гэмтлийг тодорхойлно.
- 6.2 Гэмтлийг тодорхойлсны дараа засварын ажил хийхдээ автомашины гэмтэлтэй эд ангийг салгаж засварын ажил хийнэ. Автомашины их биед гажилт үүссэн тохиолдолд гэмтээгүй эд ангийг хамгаалж татлага татна.
- 6.3 Автомашины их биеийн гэмтэлтэй эд ангийг тодорхойлсны дараа сэв гаргах ,гар болон,цахилгаан багаж ашиглан сэвийг гаргана.

- 6.4 Гэмтлийн сэв, гажилтийг гаргасны дараа автомашины их биеийг угааж замаск тавихад бэлэн болгоно. Автомашиныг угаах байгууламжийн орчны температур +5°C-с доошгүй байна.
- 6.5 Автомашины их бие угаалганд орсны дараа өө сэв дарах замаск тавина. Замаск тавих цехийн температур +20°C-с доошгүй байна.
- 6.6 Замаск тавьсан гадаргууд замаскны өө сэв дарах зүлгүүр хийнэ.
- 6.7 Зүлгүүр хийсний дараа дахин замаск тавьж зүлгүүрийн мөр дарах зүлгүүр хийнэ
- 6.8 Зүлгүүрийн дарааллыг автомашины их биеийн гэмтлээс хамааруулан сонгоно.
- 6.9 Замаск тавих гадаргууг ажилбар болгоны дараа угааж цэвэрлэнэ.
- 6.10 Замасктай гадаргууд суурь будаг (улаан замаск) шүршиж алдааг харна. Алдаа байвал дахин замаск тавьж зүлгүүр хийнэ. Будгийн цехийн температур +20°C хэмээс доошгүй байна.
- 6.11 Суурь будаг шүршинэ(Гурент) шүршинэ
- 6.12 Автомашиныг угаалганд оруулж Будгийн камер руу оруулна. Будгийн камерны хэмжээ 4:7 Будгийн камерний температур +20°C-с доошгүй байна.
- 6.13 Угаалганд орсон автомашиныг нарийн тоос шороо авах зориулалтын цавуутай алчуураар арчиж цэвэрлэнэ.
- 6.14 Автомашины их биеийн засвар хийхгүй хэсийг зориулалтын цаасан хамгаалалт ашиглан хамгаална.
- 6.15 Автомашины их биеийг будах будгийн өнгийг кодоор гаргана. Будгийг найруулна эмальтай будгийг шингэлэгчтэй найруулна.
- 6.16 Будсан машиныг +20°C-доошгүй халуун хатаах камерт хатаана.
- 6.17 Өнгөлгөөг хатах, будах ажилбарт наалдсан ширхэгийн тоосноос хамааруулан тохирох маркийн зүлгүүрийг сонгож зүлгүүр хийнэ. Зүлгүүр хийсний дараа 3 үе шаттайгаар өнгөлгөөг хийнэ.
- 6.18 Автомашины их биеийн засвар дууссаны дараа салгасан эд ангийг буцааж угсарна. Нарийвчилсан үзлэг хийнэ.

7. Автомашины их биеийн засвар эрхлэгчдэд тавих нийтлэг шаардлага

- 7.1 Нутаг дэвсгэрийнхээ бүртгэх байгууллагад тогтоосон журмын дагуу бүртгүүлж, эрхлэх ажил, үйлчилгээний нэр төрөл үйл ажиллагаа, үүсгэн байгуулах дүрэмд тодорхой заасан байх
- 7.2 Автомашины их бие засварлах ажил үйлчилгээ нь хүрээлэн байгаа орчин хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх, замын хөдөлгөөнд саад учруулахгүй, галын болон аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, хөдөлмөрийн эрүүл ахуйн болон тав тухтай ажиллах орчин нөхцлийг бүрдүүлсэн байна.
- 7.3 Ажил үйлчилгээтэй холбогдсон их бие засварын технологийн карт, технологийн болон эрүүл ахуйн шаардлага журмыг мөрдөнө.
- 7.4 Автомашины их бие засварын ажиллагаанд зориулалтын материалыг хэрэглэнэ.
- 7.5 Автомашины их биеийн засвар эрхлэгч нь технологийн картад заасан ажилбаруудыг зориулалтын тоног төхөөрөмж багаж хэрэгслээр мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэнэ.
- 7.6 Гэмтэлтэй автомашиныг засварын ажилд хүлээн авахдаа автомашин эзэмшигчид автомашины нийт явсан гүйлт, автомашины явах анги, болон автомашин хүлээлцэх акт үйлдэн ажлыг хүлээн авна.
- 7.7 Автомашины их биеийн будагчин нь химийн хорт бодисоос хамгаалах хувцас хэрэгслэлээр бүрэн хангагдсан байна. Бусад цехийн ажилчид хувийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангагдсан (малгай, бээлий, гутал, ажлын хувцас, маск, нүдний шил) байна.
- 7.8 Автомашины их бие засварын газар эмнэлэгийн анхан шатны тусламжийн багаж хэрэгсэлүүдээр бүрэн хангагдсан байна.

8. Үйлдвэрлэл, үйлчилгээний барилга байгууламжид тавигдах тавих шаардлага

- 8.1 Үйлдвэрлэл, үйлчилгээний барилга, байгууламж, түүний инженерийн шугам сүлжээ нь авто үйлчилгээний үйлдвэрлэл, үйлчилгээг явуулахад зайлшгүй шаардлагатай БНБД31-03-03 “Олон нийт, иргэний барилга”, БНБД32-04-06 “Хот суурины гудамж талбайн төлөвлөлт”-д заасан норматив шаардлагыг хангасан, будгийн тоосжилтыг шүүж цэвэршүүлэх, агааржуулах, гэрэлтүүлэх, дулаацуулах систем, галын аюулгүйн багаж хэрэгслээр бүрэн хангагдсан, тэдгээр нь хэвийн ажиллагаатай байна.
- 8.2 Галын аюулгүйн шаардлагыг бүрэн хангаж, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагын дагуу цэвэр, бохир усны системд холбогдсон эсвэл тусгай байгууламжтай байна.
- 8.3 Ажилчдын хувцас солих болон амрах байр, бие засах, гар угаах, үйлчлүүлэгчийн хүлээлгийн өрөөтэй байна.
- 8.4 Автомашины их бие засварын үйлчилгээний барилга байгууламжинд будгийн камерын ашиглалтын талбай суудлын, бага оврын ачааны болон микробус машинд ноогдох талбай 30мкв дээш байна. Ачааны автомашины чирэгч толгой болон том оврын автобус 40–80м2 дээш байх ба гэрэлтүүлэх, будгийн тоосжилтыг цэвэршүүлэн агааржуулах, хатаах төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон байх
- 8.5 Автомашины их бие засварын барилга багууламж нь агааржуулах, гэрэлтүүлэх, дулаацуулах систем, галын аюулгүйн шаардлага багаж хэрэгслээр бүрэн хангаж, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагын дагуу цэвэр, бохир усны системд холбогдсон эсвэл тусгай байгууламжтай байна.

9. Зогсоол талбайд тавих шаардлага

- 9.1 Зогсоол талбай нь MNS 5342:2007 стандарт, автотээврийн ажил, үйлчилгээ явуулах барилга байгууламж нь БНБД31-03-03, БНБД32-04-06 норм дүрмийн шаардлагын дагуу автомашин тавихад зориулж тэгшилж цардсан байна.
- 9.2 Автотээврийн ажил үйлчилгээ явуулах барилга байгууламж БНБД31-03-03 “Олон нийт иргэний барилга”, БНБД31-04-06 “Хот суурины гудамж талбайн төлөвлөлт”-д заасан норматив шаардлагын дагуу хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан автомашины болон явган хүний замтай байна.
- 9.2 Автотээврийн хэрэгсэл байрлах зогсоолын байрлалыг цагаан зураасаар, аюулгүйн тэмдэглэгээг шар зураасаар тэмдэглэж, зориулалтын зогсоолоос бусад газарт автотээврийн хэрэгсэл байрлуулахыг хориглоно.

10. Автомашины их биеийн засвар эрхлэгчийн ажиллах боловсон хүчинд тавих шаардлага

- 10.1 Автомашины их биеийн засвар эрхлэгч байгууллагын дарга, менежерийн аль нэг нь мэргэжлийн үнэмлэх, дипломтой мэргэшүүлэх сургалтанд хамрагдаж үнэмлэх гэрчилгээ авсан байна.
- 10.2 Авто их биеийн нимгэн төмөрчин, өнгөлгөөчин, будагчин, замаскачин нь засварын байрны технологи тоног төхөөрөмж багажийг бүрэн эзэмшсэн, Автомашины их биеийн засварын технологи ажиллагаа хөдөлмөр хамгаалал эрүүл ахуйн холбогдох дүрэм, журам зааврыг

судалж тэдгээрийг мөрдөж ажиллах чадвартай мэргэжлийн сургууль сургалтанд хамрагдсан насанд хүрсэн хүн байна.

10.3 Ажлын байранд хөдөлмөр хамгаалал аюулгүйн техникийн шаардлага хангасан ажлын хувцсыг өмсөж хэрэглэнэ.

11. Технологийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд тавих шаардлага

11.1 Авто их бие засвар үйлчилгээний байгууллага нь тухайн ажил үйлчилгээний технологийн картад тусгагдсан тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр иж бүрэн тоноглогдсон байна.

11.2 Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан байхаас гадна өргөж тээвэрлэх, хэмжих, хянах багаж хэрэгсэл, өндөр даралтанд ажиллах тоноглол зэрэг нь тогтоосон журмын дагуу эрх бүхий байгууллагаар шалгуулж баталгаажуулсан байна.

11.3 Суурин ба зөөврийн тоноглол нэг бүрд техник ашиглалтын бүртгэлийн дэвтэр хөтөлж, аюулгүй ажиллагааны заавартай байна.